

**Монгол-Германы санхүүгийн хамтын ажиллагаа
Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын
өөрчлөлтөд дасан зохицох төсөл
- I, II, III үе шат-
KfW-ийн үнэлгээ, хяналт шинжилгээ**

2022 оны 5 дугаар сарын 2 - 10

Хурлын тэмдэглэл

2022 оны 5-р сард хатагтай Нина Отто (Төслийн ахлах менежер) болон ноён Маттиас Бехтолшейм (БНМ-ийн ахлах зөвлөх) нараас бүрдсэн KfW-ийн төлөөлөгчид Монгол улсад айлчилж, **“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хөтөлбөр”** (БОЯБХУАӨДЗТ)-ийн I-III үе шатуудын талаар ярилцав. Уулзалт, орон нутагт ажиллаж, танилцах ажилд БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газрын дарга Д.Батмөнх, KfW-ийн Улаанбаатар дахь төлөөлөгчийн газрын захирал Майкл Зумзер, KfW-ийн төслийн зохицуулагч Ц.Энхзул, БОЯБХУАӨДЗТ-ийн ТХН-ийн төслийн зохицуулагч Г.Эрдэнэбаясгалан, ЗБ-ийн ахлах зөвлөх ноён Хартмут Аббергер болон ЗБ, ТХН -ийн ажилтнууд хамтран ажиллав. Үнэлгээний багийнхан СЯ-ны газрын дарга Ч.Чимидсүрэн, ГОУХАН-ийн төлөөлөгчид, БСТ-ийн зөвлөхүүд, мөн 2 дугаар кластерийн менежмент төлөвлөгөөг боловсруулсан зөвлөх багийнхантай уулзав. Үнэлгээний багийн зарим хүмүүс Ховд аймгийн Хар-Ус нуурын БЦГ, Хяргас нуурын БЦГ, Тарвагатайн нурууны БЦГ, Тэрхийн цагаан нуурын БЦГ, Хангайн нурууны БЦГ (бүгд монгол улсын баруун болон төвийн бүсэд) зэрэг газруудаар ажиллав. Үнэлгээний дараагийн баг Хан Хэнтийн ДЦГ, Зэд Хантайн БЦГ, Хустайн БЦГ (монгол улсын хойд ба төв бүсэд) зэрэг газруудад ажиллалаа.

Орон нутагт айлчлах, мөн уулзалт хэлэлцүүлгийн үеэр өндөр үр ашиг, үр дүнтэй ажиллах нөхцөл бүрдүүлж, уулзсан бүх албан тушаалтнууд болон бусад хүмүүсийн зочломтгой найрсаг байж дэмжлэг үзүүлсэнд гүн талархал илэрхийлж байна.

Энд орсон бүх мэдэгдэл, тайлбар нь зөвхөн үнэлгээний багийн байр суурийг илэрхийлж буйг тус баг онцлон тэмдэглэв. Санал нэгдсэн бүх ойлголтыг KfW-ийн удирдлага болон Германы Засгийн газар батална. Үүний нэгэн адил эдгээр ойлголтыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд батална.

Үнэлгээний багаас гаргасан I үе шат (1-р хэсэг) -ны хяналт шинжилгээтэй холбоотой хэлэлцэх асуудал, үр дүн болон II/III үе шат (2-р хэсэг)-ны цаашдын бэлтгэл ажлын талаар доор харуулав.

1. БОЯБХУАӨДЗТ-ийн I үе шатны үнэлгээ

1.1. Ерөнхий/дүгнэлт үнэлгээ

Үнэлгээний багаас БОЯБХУАӨДЗТ -ийн I үе шатыг үндсэндээ хэрэгжүүлж дуусаж байгаад нь БОАЖЯ, ТХН, ЗБ-т баяр хүргэлээ. Анхлан БОЯБХУАӨДЗТ-ийн I үе шатанд хэрэгжүүлэхээр

төлөвлөсөн байсан тендерүүдийг төслийн II/III үе шат руу шилжүүллээ. БОЯБХУАӨДЗТ-ийн I үе шаттай холбоотой бүх тендер, холбогдох төлбөрийг 2022 оны эцэс гэхэд дуусгана гэж төлөвлөж байна. ЭКО Консалтант компаний 3Б-ийн сүүлийн төлбөрийг энэ цаг дор бэлтгэж байна. БОЯБХУАӨДЗТ I ба II/III-тай холбоотой Зөвлөхийн төлбөрийг нэхэмжлэх хүлээн авангуут цаг алдалгүй, аль болох түргэн шуурхай гүйцэтгэхийг БОАЖЯ, СЯ-аас Үнэлгээний баг хүсэж байна.

2022 оны 5 дугаар сарын 10-ны байдлаар KfW 10.95 сая евро (нийт 11.5 сая еврогоос)-г төслийн тусгай данс эсвэл зөвлөх рүү шууд шилжүүлсэн ба тус онд багтаан үлдсэн 550.000 еврог зөвлөх болон ТХН татаж авах хэрэгтэй байна.

Монгол талаас оруулах хөрөнгө оруулалтын хүрээнд БОЯБХУАӨДЗТ I (2015-2021)-ийн хэрэгжүүлэлтэд ойролцоогоор 8.6 тэрбум төгрөгийг оруулсан. БОЯБХУАӨДЗТ I -ийн Тусгай гэрээнд 6.65 сая төгрөгийг монголын талаас оруулна гэж тооцсон байсан. Дээрх тоо нь төлөвлөсөн хөрөнгө оруулалтаас даруй 2 сая төгрөгөөр илүү гарсан байна. ТХН-тэй холбоотой зардал, мөн тусгай хамгаалалттай газар нутаг дахь ашиглалт, засвар үйлчилгээ (АЗҮ) хийхэд Монголын хөрөнгө оруулалтыг ашигласан. Энэхүү амжилтад нь төлөөлөгчийн газраас БОАЖЯ/СЯ-нд баяр хүргэж байна. Амжилттай ажилласан БОАЖЯ/СЯ-нд Үнэлгээний багийн зүгээс баяр хүргэе.

3Б нь I үе шатны эцсийн тайланг бичиж байгаа бөгөөд 2022 оны 5-р сард KfW болон БОАЖЯ-нд ирүүлнэ. Энэхүү тайланд БОЯБХУАӨДЗТ I-ийн шалгуур үзүүлэлт тус бүрээр хийсэн дүн шинжилгээ орно. KfW-ийн зүгээс жил бүр, санамсаргүй түүврийн аргаар хийдэг үнэлгээний хүрээнд БОЯБХУАӨДЗТ I-д нэмэлт төслийн дараах үнэлгээ хийж болох юм. Энэ үнэлгээг KfW-аас санхүүжүүлнэ.

Одоогийн байдлаар I үе шатанд үлдээд байгаа төсөв хөрөнгийг 2022 он дуусахаас өмнө Орчны бүсийн санд (ОБС) шилжүүлж зарцуулна.

Дүгнэж хэлэхэд, I үе шатанд ТХГН-ыг дэмжих хөрөнгө оруулалт нь ТХГН-ийн удирдлагын чадавхыг сайжруулах, улмаар урт хугацаанд биологийн олон янз байдлын хамгаалалтыг сайжруулахад хувь нэмэр оруулах зорилгоо сайн биелүүлсэн гэдэгтэй Үнэлгээний баг санал нэг байна. Иргэдийн амьжиргааг дэмжих хөрөнгө оруулалт оройтож эхэлсэн бөгөөд цар тахалтай холбоотойгоор саатсан. Гэсэн хэдий ч нийгэм, эдийн засагтай холбоотой хэрэгцээ, шаардлагыг хурдан олж тогтоосон (жишээлбэл, түргэн тусламжийн тэрэг, байгаль орчны боловсрол, ОБС болон орлого бий болгох үйл ажиллагаа).

1.2. Орон нутагт ажилласан ба хөрөнгө оруулалтаар хийсэн бараа, ажил, үйлчилгээ

Орон нутагт ажиллах үеэрээ төслийн хөрөнгө оруулалтаар бараа, дэд бүтэц, үйлчилгээний хүлээн авсан ТХГН, орчны бүсийн зөвлөл, эмнэлэг, сургуулийн ажилтан ба гишүүд, мөн дээр дурдсан тусгай хамгаалалттай газруудад амьдардаг орон нутгийн иргэдийн төлөөлөлтэй үнэлгээний баг уулзаж, ярилцав. Мөн газар дээр нь очиж танилцсан болно. Жишээлбэл, хүлэмж, усалгааны насос (БОЯБХУАӨДЗТ II/III), бүсийн сургалтын төвүүд, ХЗ ба байгаль хамгаалагчийн байр, байгаль хамгаалагчийн дүрэмт хувцас, албан тасалгааны тавилга,

тээврийн хэрэгсэл, эко кабинет, түргэн тусламжийн автомашин зэрэг нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ашиглаж байна. БОЯБХУАӨДЗТ I -ийн хүрээнд өндөр хурдтай интернет сүлжээг суурилуулсан. Уг интернет сүлжээг алслагдсан тусгай хамгаалалттай газруудад ашиглахгүй байгаа нь ашиглалтын төлбөр өндрөөс төлж чадахгүй байгаатай холбоотой байна. Нэг газар тог баригчийг (ТБ) залгаагүй байсан. Цахилгаан тоног төхөөрөмжийг хүчдэлийн хэлбэлзлээс болж эвдрэхээс сэргийлэхийн тулд тус төхөөрөмжийг холбох арга хэмжээ авахыг үнэлгээний багаас БОАЖЯ-д зөвлөж байна.

БОЯБХУАӨДЗТ II/III хувьд ТХГН-т барьж байгуулсны дараа нэмэлт зардал шаардах тоног төхөөрөмж, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс гаргана гэдгээ БОАЖЯ-аас урьдчилан баталгаажуулна.

Өмнөх хяналт үнэлгээний ажлуудын адил KfW-ийн үнэлгээний баг нийлүүлсэн бүх барааг тогтвортой ашиглахын тулд байнгын засвар үйлчилгээ хийх шаардлагатай бөгөөд түүнд шаардлагатай төсвийг баталгаажуулах нь БОАЖЯ-ны үүрэг хариуцлага гэдгийг онцлон тэмдэглэв. Мөн тус улсын ТХГН-ийн системд ашиглалт, засвар үйлчилгээний зорилгоор БОАЖЯ-наас олгосон төсвийг өндрөөр үнэлж байгаа бөгөөд 2023 оноос эхлэн БОЯБХУАӨДЗТ II/III-д төдий хэмжээний төсөв олгохыг туйлаас зөвлөж байна.

1.3. Аудит

Аудит: 2021 оны санхүүгийн жилд аудитын газраас (Хөндлөнгийн аудиторын тайлан) Германы оруулсан хөрөнгө оруулалтад алдаа гараагүй гэжээ. KfW үүнийг баталгаажуулсан болно.

1.4. Хөтөлбөрийн чухал талууд

Орчны бүсийн сан (ОБС): 2021 оны 3-р улиралд 430,000 еврог ОБС-ийн хүрээнд Төрийн банк руу шилжүүлсэн. Энэ сан нь орон нутгийн иргэд/малчдад малынхаа тоо толгойг бууруулах амлалтын хариуд хөнгөлөлттэй бичил зээл авах боломжийг олгох зорилготой юм. ОБС-г тус улсын бэлчээрийн даац хэтэрсэн, газрын доройтол зэрэг тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд нэмэр оруулна гэж үзэж байна. ОБС-ийн эрэлт маш өндөр байгаа нь оролцогч сумдад олгосон зээл богино хугацаанд гарч, эхний зээлүүд нь ТБ-нд төлөгдөж эхэлснээр батлагдаж байна. 2022 оны 3-р сард БСТ-өөс ирүүлсэн ОБС-ийн анхны үнэлгээнээс малчид малынхаа тоог бууруулах сонирхолтой, түүндээ хүрэх бодолтой байгааг харуулж байна. Дараагийн бэлчээрийн улирал болон 2022 оны 12-р сард мал тооллого хийсний дараа дахин хяналт хийх шаардлагатай. БОЯБХУАӨДЗТ II/III-ийн хүрээнд ОБС-ийн хэмжээг нэмэгдүүлэхийг үнэлгээний багаас санал болгож байна. Үүнтэй холбогдуулан 2023 оноос эхлэн ТХН-ээс жилд 2-3 удаа ОБС (БОЯБХУАӨДЗТ I ба II/III үе шатны зорилтот сумдын төлөөллийг хамруулсан) -нд мониторинг, үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний ДНТШ-ыг зохион байгуулахыг үнэлгээний баг санал болгож байна. Үүнд БОЯБХУАӨДЗТ II/III -ийн сонгогдсон сумдад ОБС-ийн хэмжээг нэмэгдүүлэхэд шаардлагатай сургалтын арга хэмжээг багтаасан байна. Хөтөлбөрийн төгсгөлд малын тоо хэмжээг тогтвортой бууруулсан, бэлчээрийн чанар сайжирсан, түүнчлэн илүү ашиг шим өндөртэй үүлдэр угсааг гаргасан эсэх зэрэг үр дүнд төвлөрсөн ОБС-ийн нөлөөллийн үнэлгээг тусад нь хийнэ.

Тогтвортой амьжиргааг дэмжих ажлын хүрээнд (хадлан хадах, усалгааны систем, хүлэмж болон ногоон тэжээл тарих гэх мэт.) орчны бүсийн нөхөрлөлүүдэд нэмэлт орлого бий болгох үндэс суурийг бүрдүүлсэн. Гэсэн хэдий ч тэдэнд өгч байгаа хөрөнгө оруулалт болон ТХГН-т ирэх дарамтыг бууруулах хооронд ямар ч холбоо байхгүй байгаа ба цаашид БОЯБХУАӨДЗТ II/III үе шатны иргэдийн амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээг боловсруулахад анхаарах хүчин зүйл болж байна. Доороос үзнэ үү.

Хустай БЦГ-т хийх нэмэлт ажлууд: Барилгын эвдрэл гэмтэлтэй холбоотой барилгын оношилгоо саяхан хийгдсэн. Энэхүү оношилгооны үндсэн дээр засварын ажлыг анх барилгын ажил гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр санхүүжүүлнэ.

2. БОЯБХУАӨДЗТ II/III

2.1. Хэрэгжилтийн өнөөгийн байдал ба нөхцөл байдал

Төслийн эхний 18 сард Корона тахлын дэгдэлт тохиолдсон бөгөөд хөл хорио тогтоох, хөдөө орон нутаг болон улс хооронд зорчих, уулзалт, сургалтад оролцохыг хязгаарласан. 2021 оны сүүл, 2022 оны эхэн үеэс хойш хязгаарлалтыг нэлээд цуцалсан нь төслийн үйл ажиллагааг зохих хурдацтай хэрэгжүүлэх боломжийг олгож байна. Иргэдийн амьжиргааг дэмжих эхний арга хэмжээнээс (хүлэмж, усалгааны системийн тоног төхөөрөмж) гадна өөр ямар нэг тоног төхөөрөмжийг ТХГН, тэдгээрийн орчны бүсүүдэд нийлүүлээгүй байгаа нь оролцогч талууд төслийн үйл ажиллагаанд итгэл алдрах эрсдэлийг дагуулж байна. Мөн ахиц дэвшил гарахгүй байгаагаас ТХГН-ийн хамгаалалтад сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа (хог хаягдал, хулгайн ан, ТХГН-ийг малын бэлчээр болгон ашиглах гэх мэт) тасралтгүй үргэлжилсээр байна.

Энэ хугацаанд ХБНГУ-ын Засгийн газраас ХБНГУ-ын хөгжлийн хамтын ажиллагааны шинэчилсэн стратегийн хүрээнд Монгол Улстай хоёр талын хамтын ажиллагаагаа үе шаттайгаар зогсоох шийдвэр гаргасан. Энэ нь БОЯБХУАӨДЗТ II/III -ийг 2026 оны эцсээр дуусгавар болгосноос хойш Монгол Улсын ТХГН-ийг сүлжээнд нь дэмжих зорилгоор цаашид ямар ч санхүүжилт олгохгүй гэсэн үг юм. Үүссэн нөхцөл байдлаас хамаарч төслийн бүх талууд (жишээлбэл, БОАЖЯ, ТХН/ЗБ болон KfW) давхар сорилттой тулгарч байна: нэг талаас БОЯБХУАӨДЗТ II/III арга хэмжээг аль болох үр ашигтайгаар хэрэгжүүлэх; нөгөө талаар чанар, тогтвортой байдлын стандартыг зөрчихгүй байх. 2026 оны 12-р сар гэхэд зарцуулагдаагүй үлдсэн Германы санхүүжилт цаашид боломжгүй болно гэдгийг үнэлгээний багаас онцлон тэмдэглэв.

Энэхүү үнэлгээний ажил эхлэхээс өмнө KfW болон ТХН/БОАЖЯ хамтран хөтөлбөрийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн хэд хэдэн алхмуудыг (агентлагийн гэрээнд гарын үсэг зурах, ЗБ-ийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах бэлтгэл ажлыг хангах, ДНТШ барааны босго үнийг 1 сая евро болгон нэмэгдүүлэх, улсын хэмжээнд нийлүүлэх) хэлэлцэж тохиролцсон. Цаашлаад, өргөн хүрээний зохицуулалт, техникийн туслалцаа шаардлагатай байгаа тул анх төлөвлөсөн кластераар хэрэгжүүлэх арга хэмжээг (кластерын менежментийн төлөвлөгөө болон кластерийн менежментийн зөвлөл) хойшид мөрдөхгүй болохыг энэ хурлын тэмдэглэлд гарын үсэг зуралцсанаар харилцан зөвшөөрсөнд тооцно. Мөн эко коридор байгуулахыг

дэмжихээ зогсооно. Харин БОЯБХУАӨДЗТ II/III хүрээнд Монгол Улсын ТХГН-ийн тогтолцоонд дэмжлэг үзүүлэх бөгөөд а) үндсэн тоног төхөөрөмж, бараа, ажил, үйлчилгээг улсын хэмжээнд санал болгох, б) баруун бүсийн кластеруудын ТХГН болон 3 дугаар бүрэлдэхүүн хэсэгт хамрагдсан 7 ТХГН-т нэмэлт дэмжлэг, хөрөнгө оруулалт хийх зэрэг юм. б)-д заасан санхүүжилтэд иргэдийн амьжиргаа болон нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт багтана. Санал болгож буй үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээг нэг бүрчлэн дараагийн хэсэгт тодотгов. Кластерийн менежментийн зөвлөлийг (КМЗ) 5 кластерт зориулан байгуулсан боловч цаашид үндсэн чиг үүргээр нь дэмжихгүй (2019 оны санамж бичигт заасан). ТХН/ЗБ хэрхэн үүнийг КМЗ-д хүргэх талаар бодох хэрэгтэй. Гол санаа нь ТХГН-ууд болон кластерийн иргэдэд хийх хөрөнгө оруулалт анх төлөвлөсний дагуу хийгдэх болно.

2.2 Төслийн зардал, санхүүжилтийн төлөвлөгөөг дахин хянах

Дээр дурдсан өөрчлөлттэй холбогдуулан ТХН нь БОЯБХУАӨДЗТ II/III-ийн шинэчилсэн зардал, санхүүжилтийн төлөвлөгөөг (З+СТ) 2022 оны 6-р сарын 10-ны дотор бэлтгэж, KfW-д хүргүүлж, зөвшөөрөл авна. Шинэчлэгдсэн З+СТ-нд боломжит санхүүжилтийг 1-р бүрэлдэхүүн хэсэг (улсын хэмжээнд менежмент төлөвлөгөө, үндсэн тоног төхөөрөмж), 2-р бүрэлдэхүүн хэсэг (Баруун бүсийн хуучин кластерт хамрагдах 12 ТХГН-ийг дэмжих, амьжиргаа дээшлүүлэх), 3-р бүрэлдэхүүн хэсэг (Монголын өмнөд нутгаас сонгогдсон 7 ТХГН-ийг дэмжих ба амьжиргааг дээшлүүлэх) болон 4-р бүрэлдэхүүн хэсэг (сургалт, судалгаа)-т боломжит санхүүжилтийг нийцүүлэн хуваарилна. 2 ба 3 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хувьд санхүүжилтийн хэдэн хувь ТХГН-ийг дэмжихэд, хэдэн хувь нь иргэдийн амьжиргааг дэмжихэд зарцуулагдахыг тооцож гаргана. Шинэчилсэн төсөвт үндэслэн ТХГН болон тэдгээрийн орчны бүс/сум бүрээр боломжит санхүүжилтийн хэмжээг ТХН илүү нарийвчлан тооцоолох боломжтой.

2.3 Худалдан авалт, төслийн хэрэгжүүлэлтийн үр дүнг өргөжүүлэх алхмууд

2.3.1 Агентлагийн гэрээ

Агентлагийн гэрээнд БОАЖЯ, KfW хамтран 2022 оны 3 дугаар сарын 30-нд гарын үсэг зурсан. Тус гэрээгээр KfW Зөвлөхийн 5 дахь төлбөрөөс эхлэн бүх төлбөрийг хийнэ.

2.3.2 ЭКО-ийн ЗБ-ийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах

ТХН болон ЗБ-аас Зөвлөхийн гэрээнд тэг зардалтай нэмэлт өөрчлөлт оруулах саналыг БОАЖЯ-нд санал болгосныг KfW-д мэдэгдсэн. Тухайн нэмэлт өөрчлөлтөөр төслийн бүрэлдэхүүн хэсэг бүрд шаардлагатай үйл ажиллагааг зохих ёсоор хангахын тулд ЗБ-ийн зөвлөх үйлчилгээний төлбөрийг дахин хуваарилах юм. Мөн энэ нэмэлт өөрчлөлтөд агентлагийн гэрээнд нийцүүлэн ЗБ-ийн төлбөрийг (2.3.1-ийг харна уу) тусгах ба хэд хэдэн нэмэлт нөхөн тооцох ажлыг тусгах болно. Нэгэнт кластерийн арга барилаас татгалзсан тул кластерийн менежментийн төлөвлөгөөг боловсруулахад шаардагдах нөхөн тооцох зардлыг (2-р кластерийн КМТ-ний төлбөр болон ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөний зардлаас бусад) зөвлөхийн гэрээнээс хасаж, төслийн нийт төсөвт буцаан оруулна. Санал болгож буй өөрчлөлтийн талаар KfW эерэг байр суурьтай байгаа бөгөөд үг баримт бичгийг хүлээн авмагцаа БОАЖЯ-аас даруй хянан үзэж, төлөвлөсөн ажлуудаа цаг тухайд нь хэрэгжүүлэх

боломжийг олгох үүднээс KfW-д илгээн албан ёсны зөвшөөрөл авахыг хичээнгүйлэн хүсэж байна.

2.3.3 ДНТШ-ын дээд үнийг 1 сая хүртэл евро болгов

БОЯБХУАӨДЗТ II/III-тай холбоотой KfW-ийн худалдан авах ажиллагааны удирдамжийг 2021 онд шинэчлэхдээ KfW-аас ДНТШ барааны дээд үнийг 1 сая евро болгон нэмэгдүүлэхийг санал болгосон (2019 оны удирдамжид 200,000 евро байсантай харьцуулаад). Энэ нь KfW-аас урьдчилан зөвшөөрөл авалгүй ийм төрлийн тендер явуулах боломжийг ТХН-д олгох зорилготой юм. БОАЖЯ болон СЯ энэ саналыг албан ёсоор зөвшөөрсөн байна (2022 оны 4-р сарын 6-ны өдөр тохиролцож, гарын үсэг зурсан). Энэхүү албан бичигт гарын үсэг зурсны дараа ТХН нь 2022 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөө (ХАТ) шинэчлэн боловсруулж, ийм үнийн дүнтэй тендерийг ДНТШ (ОУНТШ биш) хэлбэрээр явуулах болно. Төлөвлөсөн тендерүүдийг аль болох хурдан эхлүүлэхийн тулд шинэчилсэн ХАТ-г даруй батлахыг БОАЖЯ-аас үнэлгээний баг хичээнгүйлэн хүсэж байна. 2023 оноос эхлэн KfW жил бүр хоёр хүртэлх явагдсан тендерийг хянан шалгах эрхтэй. Энэ хяналтыг тендер дууссаны дараа хийнэ (өмнөх тендерүүдийг шат бүрд нь хянадаг байсантай адилгүй). KfW жил бүрийн худалдан авалтын төлөвлөгөөний үндсэн дээр хянан үзэх тендерийг түүврээр сонгоно.

2.3.4 Улсын хэмжээнд хэрэгжүүлэх нэмэлт тендерүүд

ТХГН-дад тулгарч буй тоног төхөөрөмжийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд KfW болон ТХН/БОАЖЯ хамтран улсын хэмжээнд (өмнө байсан 5 кластерийн ТХГН болон сонгогдсон 7 ТХГН-аар хязгаарлахгүй) хэд хэдэн тендерийг хэрэгжүүлэхээр тохиролцсон байна. Үүнд: байгаль хамгаалагчийн дүрэмт хувцас, тээврийн хэрэгсэл, үндсэн тоног төхөөрөмжийн тендер зэрэг багтаж байна. Төсөл дуустал тухайн хамгаалалттай газрын хэрэгцээ шаардлагад тохирсон ажил, бараа, үйлчилгээний тендерийг улсын хэмжээнд, нийгэм, эдийн засгийг дэмжих тендерийг орон нутгийн хүрээнд зохион байгуулахаар дараа дараагийн худалдан авалтдаа тусгахыг KfW-ийн зүгээс зөвлөж байна.

2.3.5 БОАЖЯ-аас шаардлагуудыг гаргаж, хүргүүлэх

БОЯБХУАӨДЗТ II/III хөтөлбөрийн хүрээнд KfW Монгол улсын ТХГН-г сүлжээний хэмжээнд дэмжих зорилгоор ХЗ-ын барилга, байгаль хамгаалагчийн байр, отоглох хоноглох цэг зэрэг олон ажлыг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн. БОЯБХУАӨДЗТ II/III-ийн үр дүнг дээшлүүлэх зорилгоор зөвхөн байгаль хамгаалагчийн байрыг санхүүжүүлэхээр болов. Эдгээр байрны зураг төсөл, техникийн нөхцөлийг боловсруулахад БОАЖЯ-ны шаардлага, стандартыг оруулах ба 2022 оны 6-р сарын 15-ны дотор ТХБНУГ-аас барилгатай холбоотой ерөнхий шаардлагыг ТХН/ЗБ-т хүргүүлнэ. 2022 оны 9-р сарын 15-ны дотор төслийн I үе шатанд зураг төслийн компанитай байгуулсан гэрээнд өөрчлөлт оруулах эсвэл өөр компанитай шууд гэрээ байгуулах замаар явуулна. Гэрээт компани нь дээр дурдсан барилгын ерөнхий шаардлагууд болон төслийн I үе шатнаас авсан сургамжид (жишээ нь, ариун цэврийн байгууламжийг оруулах) үндэслэн анхны зураг төслийг өөрчлөн засварлана. Засварласан зураг төслийг 2022 оны 12-р сар дуусахаас өмнө БОАЖЯ-нд ирүүлнэ. Хүлээж авснаас хойш 2 долоо хоногийн

дотор БОАЖЯ санал/шаардлагаа нэмж оруулна. Хэрэв 2023 оны 2 дугаар сарын эхэн гэхэд бичиг баримтан дээрээ зөвшилцөлд хүрээгүй нөхцөлд тус ажлыг хийх төслийн санхүүжилтийг олгох боломжгүй болно.

2.3.6 ТХН-ийн ажилтнууд орон нутагт ажиллах санхүүжилт

БОЯБХУАӨДЗТ-ийн бүрэлдэхүүн хэсэг бүрд гарч буй ахиц дэвшил, сорилт бэрхшээл, холбогдох шийдвэрийг гаргахад ЗБ болон ТХН-ийн ажилтнууд тогтмол орон нутаг болон мониторингийн томилолтоор ажиллах нь чухал ач холбогдолтой. Орон нутагт ажилласнаар олж авсан ойлголт, сургамжгүйгээр ТХН нь удирдлагын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болно. Иймд үнэлгээний багаас ТХН мониторингийн үйл ажиллагааг тогтмол хийх томилолтын хүрэлцэхүйц төсөв гаргахыг Монголын түншүүдэд шаргуу зөвлөж байна.

2.4 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх тодорхой элементүүд

2.4.1 Төлөвлөгдсөн ББССМТ, Ховд: ББТ-ийн барилгын талбайг сонгон, чөлөөлсөн хэдий ч хэмжээ, ашиглалтын үзэл баримтлал, зориулалт, төсөв, мөн хоол, байраар үйлчлэх зэрэг асуудлууд хоёр жилийн бэлтгэл ажлын дараа өнөөг хүртэл шийдэгдээгүй хэвээр байна. Одоогоор хийгдэж байгаа жижиг үнэлгээ нь шийдвэр гаргахад тус болохгүй. Хэрэгцээ шаардлагын сайн үнэлгээ хийлгэж, үйл ажиллагааны үзэл баримтлалыг гадны зөвлөхөөр боловсруулж (шууд гэрээ) KfW-д 2022 оны 10 дугаар сараас хоцролгүй танилцуулахыг үнэлгээний багаас зөвлөж байна. Төвийн зураг төслийг боловсруулах архитектортой 2022 оны 12-р сараас өмнө гэрээ байгуулсан байна. Санал болгож буй төсвийг дээр дурьдсан шинэчилсэн 3+СТ-нд нийцүүлэн ТХГН-т олгох хөрөнгө оруулалттай тааруулах ба ТХГН-ийг дэмжих бусад хөрөнгө оруулалтыг хязгаарлахгүй байна. Үнэлгээний багийн зүгээс ББССМТ-ийг Хангайн нурууны БТ-тэй (арай том хурлын танхимтай байж болно) хэмжээ, төсвийн хувьд ойролцоо байлгахыг зөвлөж байна.

2.4.2 Говийн Их Дархан газар Б хэсгийн олон үйл ажиллагаат ХЗ-ны барилга: ОУТГ нь Алтай суманд баригдах олон үйл ажиллагаат ХЗ-ны барилгын зураг төсөл, төсвийг гаргасан. Түүний дараа БОАЖЯ Их говийн ДЦГ -ыг хоёр өөр ТХГН болгон хуваасан. Тиймээс уг барилга нь анх сонгосон суманд байх эсэх нь шийдэгдээгүй хэвээр байна. Асфальтан замд ойр байршилтай, ОУТГ зураг төслийг нь боловсруулж бэлэн болгосон зэргийг харгалзан Алтай сумын байршил нь хамгийн тохиромжтой гэж үнэлгээний баг үзэж байна. Төлөвлөж буй барилгын байршлыг 2022 оны 9-р сарын сүүлээс өмнө Монголын тал бичгээр баталгаажуулж өгөхийг үнэлгээний багаас хичээнгүйлэн хүсэж байна. Эс бөгөөс тус барилгыг БОЯБХУАӨДЗТ II/III-ын хүрээнд санхүүжүүлэхээ зогсооно.

2.5 Бие даасан 7 ТХГН-ийг сонгох: Санал болгож буй өөрчлөлттэй (жишээ нь, Булнайн нуруу, Тэс голын БЦГ-ыг Нөмрөгийн ДЦГ-аар сольсон) холбогдуулан ТХН/ЗБ-аас үнэлгээний үр дүн, тайлбарыг улирлын тайландаа оруулан KfW руу илгээж, зөвшөөрөл авна.

2.6 ТХГН-т хэрэгжүүлэх иргэдийн амьжиргааг дэмжих үйл ажиллагаа

Амьжиргаа дээшлүүлэх/нийгэм-эдийн засгийн бүх үйл ажиллагааны хүрээнд байгаль хамгааллын уялдаа холбоог сайжруулахын тулд ТХН нь ЗБ-ийн дэмжлэгтэйгээр үзүүлж байгаа нийгэм, эдийн засгийн дэмжлэг бүрийг холбогдох ашиг хүртэгчид болон/эсвэл орон нутгийн

удирдлагын зүгээс (санхүүгийн) биологийн олон янз байдлыг хамгаалах талаарх амлалт/ТХГН-ийг дэмжих ажлыг цаг тухайд нь, зохих ёсоор хэрхэн хангахыг харуулсан концепц боловсруулахаар тохирлоо. Тус концепцийг 2022 оны 6-р сарын 30-ны дотор KfW руу зөвшөөрөл авахаар явуулна гэж найдаж байна. Цаашлаад, шинэчлэгдсэн үзэл баримтлалын хүрээнд анх хийхээр төлөвлөж байсан нийгэм-эдийн засгийн суурь судалгааг хийх шаардлагагүй гэж үзэж байна.

2.7 БОННМ

Харилцан тохиролцсон үзэл баримтлалын өөрчлөлтийн хүрээнд (ялангуяа Кластерын Мен.Төлөвлөгөөг хассан - дээрээс харна уу) БОННМ-ийн шаардлага мэдэгдэхүйц буурах төлөвтэй байна. Гэсэн хэдий ч аюулгүйн зарим асуудлыг зохих ёсоор анхаарч үзэх шаардлагатай хэвээр байна.

2022 оны 5 дугаар сарын 9-нд Улаанбаатар хотод гарын үсэг зурав.



БОАЖЯ-ыг төлөөлж

Э.Баттулга

Төрийн нарийн бичгийн
дарга, БОАЖЯ



KfW-г төлөөлж

Хатагтай.Нина Отто

Төслийн ахлах
менежер